



## **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

### **1.Хууль зүйн үндэслэл**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны бодлогын баримт бичгийн 4.3.8-д “Урт хугацааны даатгалын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэж, 4.3.9-д “Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж, 4.3.10-д “Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.15-д “Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 42-т “Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг 2021 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тус тус заасан.

### **2.Практик шаардлага**

Монгол Улсын Их Хурлаас Даатгалын тухай хуулийг анх 1997 онд баталж, 2004 онд шинэчлэн найруулсан бөгөөд уг хуулиар даатгалын салбарын эрх зүйн үндсийг тогтоож, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн.

Монгол Улсын даатгалын зах зээл дээр одоогоор ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 2 компани болон давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа эрхэлж байна. Даатгалын компаниуд 2019-2023 онуудад хураамжийн нийт орлогын 34.0 хувийг буюу нийт 449.9 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна. Энэ нь нэгдүгээрт, дотоодын давхар даатгалын компанийн хүчин чадал хангалттай хэмжээнд хүрээгүй, хоёрдугаарт, дотоодын даатгалын компаниудын нөөц хөрөнгө хангалтгүй байгаатай холбоотой байгааг харуулж байна. Иймд гадагш шилжүүлж буй валютын урсгалыг бууруулах, дотоодын даатгагч нарын чадавхыг бэхжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих шаардлагатай байгаа бөгөөд дээрх шаардлагын хүрээнд дотоодын



давхар даатгалын компанид ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд эрсдэлийн тодорхой хэсгээ шилжүүлж байх шаардлагыг хуульд тусгах нь зүйтэй байна. Түүнчлэн, давхар даатгагчаас өөр субъектэд эрсдэлийг шилжүүлэх, эрсдэлийг санхүүжүүлэх хөрөнгийн шинэ эх үүсвэрийг бий болгох буюу даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон, даатгалын эрсдэлийг тархаан байршуулж, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Мөн даатгалын үнэлгээ ихтэй даатгалын гэрээг дотоодын даатгагчид дангаар хийх боломжгүй нөхцөлд үнэлгээний дийлэнх хэсгийг гадаад даатгагчаар даатгуулах, давхар даатгагчид шилжүүлэх тохиолдлууд гарсаар байна. Иймд даатгагчдыг хамтын даатгал хийх, даатгалын хураамжийн зохистой хувийг дотоодод үлдээх, дотоодын даатгалын зохицуулалт, нэр томьёо, даатгалын зүйлийн зохицуулалтыг тодорхой болгох, гадаадын даатгагчид тавих хяналт, бүртгэлийг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Техник технологийн хөгжил, даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг даатгуулагчид ойртуулах, зардлыг бууруулах боломж нээгдэж байгаа боловч өнөөгийн хууль, эрх зүйн хүрээнд даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явцад баримт бичгийг цаасаар бүрдүүлэх, бичгээр баталгаажуулах шаардлагууд хэвээр үйлчилсээр байна. Иймд даатгалын гэрээг цахимаар байгуулах боломжийг хууль, эрх зүйн хувьд нээх, даатгалын баталгаа, холбогдох байгууллагын дүгнэлт, акт материал зэргийг эх хувиар бүрдүүлэх зэрэг зарим шаардлагыг засч, өөрчлөн найруулах шаардлагатай байна. Ингэснээрээ даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үйл явцыг хялбаршуулж, цаг хэмнэх, иргэн болон даатгагчид үүсэх зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

Даатгал бол эрсдэлийг бууруулах, эрсдэлээс хамгаалах санхүүгийн хэрэгсэл бөгөөд учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тооцоолоход төрөл бүрийн тоо, мэдээлэл болон мэргэжлийн тооцоолол ихээр шаардагддаг. Гэтэл манай улсын даатгалын зах зээлд оролцогчдод хангалттай мэдээлэл байдаггүйн улмаас даатгалын хураамж эрсдэлийн түвшинтэй уялддаггүй, энэ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Даатгалын мэдээллийн сангийн үйл ажиллагааг шинэлэг байдлаар зохицуулах асуудлыг хуульд тусгаснаар даатгагчид болон даатгалын салбарын мэргэжлийн оролцогчдод даатгалын хураамжийг илүү бодитоор тооцоолох, эрсдэлийн үнэлгээ хийх, бүтээгдэхүүн, үйлчилгээндээ дэвшилтэд техник, технологийг өргөн хүрээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Мөн даатгалын зах зээлийг илүү ёс зүйтэй, хариуцлагатай, тоо, мэдээлэлд суурилсан салбар болгох зорилгоор даатгалын зах зээлд оролцогчдын мэргэжлийн ёс зүй болон үйлчилгээний хэм хэмжээг тогтоох, хэвшүүлэх, тэдгээрт тавих хяналтыг сайжруулах, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зэрэг зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Олон улсын жишгээр даатгалыг амьдралын болон амьдралын бус даатгал гэж ангилж үздэг. Монгол Улсын Даатгалын тухай хуулиар даатгалыг ердийн болон урт хугацааны даатгал гэж ангилсан байх боловч тэдгээрийн ялгааг хуулиар нарийвчлан зохицуулаагүй нь даатгуулагч даатгалын гэрээг буруу ойлгох, даатгалын тохиолдол нь гэрээний нөхцөлд хамаарах эсэх талаарх маргаан нэмэгдэх нөхцөл байдлыг үүсгэж байна. Иймд даатгалын ангиллын ялгааг тодорхой болгох, ангиллын нэршлийг



хэрэглэгчдэд илүү ойлгомжтойгоор томъёолох нь хэрэгцээтэй байна. Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан дундаж давхаргыг дэмжсэн, бага дунд орлоготой иргэд, аж ахуйн нэгжийг эрсдэлээс хамгаалсан хүртээмжтэй даатгал, урт хугацааны даатгалын зохицуулалтыг боловсронгуй болгож, тэтгэвэр, хуримтлалыг бодлогоор дэмжин ажиллах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Олон улсыг хамарсан санхүүгийн хямрал болоход санхүүгийн байгууллагуудын удирдлага, хяналтыг сайжруулах хүрээнд улс орнууд тухай бүр шинэлэг зохицуулалтыг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Тухайлбал, даатгалын салбарт даатгуулагчийн төлсөн хураамж, хөрөнгийг зөв зохистой удирдах, хууль бус үйлдлийг хязгаарлах зорилтын хүрээнд даатгалын компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулахад анхаарал хандуулах болсон. Манай улсын хувьд эдгээр асуудлыг журмаар зохицуулахаас илүүтэй хуулиар зохицуулж, тэдгээрийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох бодит шаардлага тавигдаж байна.

Даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын орчин нь бизнесийн ёс зүйн үүднээс тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болж, тэдгээрийн зөрчил, дутагдалд тохирсон урьдчилан сэргийлэх, засаж залруулах арга хэмжээ авч чаддаг байхыг шаарддаг тул даатгалын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын орчныг хуулийн хүрээнд бий болгох зайлшгүй нөхцөл шаардлага байна.

Олон улсын туршлага, судалгаанаас харахад, даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй байна. Тодруулбал, даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх хүсэлт гаргаж буй даатгагч болон нэгтгэн авч буй даатгагчийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй байхыг баталгаажуулах, энэ үйл ажиллагаанд хамрагдаж буй даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдаж буй эсэхийг мөн анхаарах хэрэгтэй байна.

Түүнчлэн, үнэлгээчний хариуцлага, өмгөөлөгчийн хариуцлага, агаарын хөлгийн зорчигчийн даатгал гэх мэт тодорхой төрлийн хуулийн этгээдийн харилцагч, ажилтан, эсхүл холбогдох хөндлөнгийн этгээдийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий заавал даатгалын шинж чанартай даатгалын хэлбэрүүд 20 гаруй салбарын хуулиудад тусгагдаж, зохицуулагддаг хэдий ч тэдгээрийн хэрэгжилтийг хангах механизм тодорхойгүй, хуулиар “заавал даатгал” гэх ойлголтыг тодорхойлоогүй, заавал даатгалын нэгдсэн бодлого зохицуулалтгүйн улмаас хуулийн хэрэгжилтийн үр дүн, хяналт орхигдсон хэвээр байгаа тул заавал даатгалыг нэвтрүүлэх асуудлыг хуульд тусгах шаардлагатай байна.

Цаашилбал, албан журмын даатгагчдын холбооны статус, бүтцийг өөрчлөн зохион байгуулж, эрх, үүрэг, тавих хяналтыг эрх зүйн хувьд засаж залруулах, өөрийн байгууллагадаа даатгалын гэрээ зуучилж байгуулсны төлөө шан харамж авах, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж, даатгалын компаниуд шударгаар өрсөлдөх боломжийг хязгаарлаж буй даатгалын орлогын шимтгэлийн асуудлыг шийдвэрлэх, даатгуулагчийн эрх бүхий ажилтан, албан хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийг даатгалын төлөөлөгч болгох замаар шууд болон шууд бусаар мөнгөн болон мөнгөн бус урамшуулал, шагнал олгохыг хуулиар хориглох зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Иймд Монгол Улсад даатгалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, олон тулгуурт даатгалын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох,



даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллага болон даатгалын салбарын оролцогчдын хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, даатгалын салбарын хяналтын шинэлэг зохицуулалтуудыг зайлшгүй нэвтрүүлэх шаардлага бий болж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслөөр даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, түүнчлэн дотоодын давхар даатгалын үйл ажиллагааг дэмжих, даатгалын компанийн засаглал, хяналтын тогтолцоог боловсронгуй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах болно.

Даатгалын тухай хуулийг дараах агуулгаар өргөжүүлэн шинэчилнэ:

#### **1.Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд:**

- дотоодын давхар даатгагчдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор дотооддоо эрсдэлийн тодорхой хувийг заавал даатгуулдаг болох;
- даатгагчдын хамтын ажиллагааг дэмжих хүрээнд хамтын даатгал хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- даатгалын эрсдэл шилжүүлэх бусад арга хэрэгсэлтэй холбогдох шинэ зохицуулалтыг тусгах;
- эрсдэлд суурилсан хяналт шалгалт, нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгох зохицуулалтуудыг тусгах;
- даатгалын компанийн засаглалд тавигдах шаардлага болон түүнд тавих төрийн хяналт, зохицуулалтыг тусгах.

#### **2.Амьдралын даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, сайжруулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хүрээнд:**

- даатгалын ангиллын нэршлийг өөрчилж, олон улсын жишигт нийцүүлэн, амьдралын даатгалын, ердийн даатгалын нэр томьёо, зааг ялгааг шинэчлэн тодорхойлох, амьдралын даатгал, тэтгэврийн даатгал, хуримтлалыг хөгжүүлэх, бодлогоор дэмжих зохицуулалтуудыг бий болгох.

#### **3.Даатгалын үйл ажиллагааг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хүрээнд:**

- даатгалын гэрээ, даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой одоогийн зохицуулалтуудыг хялбаршуулж, даатгалын гэрээг цахим хэлбэрээр хийх, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг цахим хэлбэрээр гаргах нөхцөлийг бүрдүүлэх, дэвшилтэд техник технологийг ашиглах эрх зүйн боломжийг бүрдүүлэх;
- төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зорилгоор салбарын мэргэжлийн оролцогчдын оролцоог хангасан даатгалын зах зээлийн



хөгжлийг дэмжих мэргэжлийн байгууллагын зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгах.

**4.Заавал даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хүрээнд:**

- хууль тогтоомжид заавал даатгуулахаар тусгасан заалтуудын хэрэгжилтийг сайжруулах хүрээнд даатгалын харилцаа тусгагдсан бусад хуулиудын зохицуулалтыг сайжруулах, тэдгээрийг нэгдсэн байдлаар зохицуулах;
- албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг шинэчлэх, сайжруулах;
- заавал даатгалын баталгаат сан болон мэдээллийн нэгдсэн сангийн зохицуулалтыг бий болгох.

**5.Салбарын бусад зохицуулалтуудыг сайжруулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хүрээнд:**

- даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох;
- даатгалын зах зээлийн зохистой үйл ажиллагаа, зах зээлд оролцогчдын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээтэй холбогдох зохицуулалтыг сайжруулах;
- даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулах;
- даатгалын хохирол үнэлэгч, даатгалын орлогын шимтгэлтэй холбогдох зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгах;
- даатгалын нөхөн төлбөртэй холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулах талаар тусгах;
- дээрх зохицуулалтуудтай холбоотой өөрчлөлтүүдийг даатгалын журамд тусгах.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах тогтолцоо боловсронгуй болж, даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчны тодорхойгүй байдал буурах, дотоодын даатгагчдын чадавх нэмэгдэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжрах бөгөөд үүний үр дүнд даатгалын салбар дунд хугацаанд өргөжин тэлэх ач холбогдолтой болно.

Түүнчлэн, цахим дэвшилтэд техник технологид суурилсан даатгал, эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус арга зам зэрэг олон улсын жишгийн дагуу урт хугацаанд даатгалын салбарыг хөгжүүлэх эрх зүйн суурь бүрэлдэн бий болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулна. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

--oOo--